



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2005 оны 6 сарын 13 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Г Нийслэлийн өмчит үйлдвэрийн зарим газруудыг татан буулгах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2005 оны 1/1012 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. “Балчирхан”, “Чингэлтэйн үйлдвэр сургалтын төв”, “Хан-Уул хангамж”, “Сүх жанжин”, “Тахилт” нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудыг 2005 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

Хоёр. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийн асуудлыг тухайн байгууллага өөрөө хариуцах, түүнд тавих мэргэжлийн болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох, татан буугдсан дээрх нийслэлийн өмчит газруудын өр авлагын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч / М. Энхболд/-д үүрэг болгосугай.



ДАРГА  
НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА  
ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД:

*Балчирхан* Н. БОЛОРМАА  
*Т. Билэгт* Т. БИЛЭГТ  
*Ш. Алтангэрэл* Ш. АЛТАНГЭРЭЛ  
*Я. Аюушжав* Я. АЮУШЖАВ  
*Д. Баасансүрэн* Д. БААСАНСҮРЭН  
*С. Баярмөнх* С. БАЯРМОНХ  
*Г. Мөнхбаяр* Г. МӨНХБАЯР  
*С. Отгонбат* С. ОТГОНБАТ  
*Б. Ундармаа* Б. УНДАРМАА